



МОНГОЛ



МОНГОЛООРОО ОВОГЛОСОН

МОНГОЛ ХАДРАН



ДЭЛХИЙН ТАРХАЦ


Манай орны унаган зүйл Монгол хадран загас (*Thymallus brevirostris* Kessler, 1879) нь мөстлөгийн үеийн төлөөлөл юм.

4.5 сая

жилийн өмнө Монгол орны баруун бүсийн нууруудад түүний өвөг суурьшсан гэж судлаачид үздэг.



Монгол орны баруун бүсийн Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Ховд, Буянт, Бөхмөрөн, Хариг, Чигэстэй, Богд, Яруу, Завхан гол, Хотон, Хурган, Даян, Ачит, Хар, Хар-Ус, Хонгор Өлөн, Толбо, Хөх нуурт тархан амьдарна.




АМЬДРАХ ОРЧИН

Монгол хадран загас нь цэнгэг, хүйтэн устай гол, нуурт амьдарна.




АНГИЛАЛ ЗҮЙ

Манай оронд Яргайтаны баг (Salmoniformes), Хадрангийнхны овог (Thymallidae), Хадрангийн (Thymallus) төрөлд багтах 5 зүйлийн загас байдаг.




ТАНИХ ШИНЖ ТЭМДЭГ



Монгол хадран (*Thymallus brevirostris*) загас нь идэш тэжээл, амьдрах орчин, морфологи шинж тэмдгээрээ ялгаатай ёроолын идэшт болон махчин махчин гэсэн хоёр хэлбэр үүсгэдэг.

ЁРООЛЫН ИДЭШТ



МАХЧИН



ИДЭШ ТЭЖЭЭЛ



Монгол хадран усны ёроолын шавж, усны ургамал болон загасаар хооллоно.



Махан идэшт хадрангийн идэш тэжээлийн бүрэлдэхүүний **60-70%**-ийг загас эзэлнэ.



НАС, ӨСӨЛТ

Атуу (эм загас) нь **атуух** (эр загас)-аа бодвол биеэр том байдаг.

♀



♂



CM



16+ нас

Өндөр уулын нууруудад



8+ нас

Бусад нуур, голуудад

ҮРЖИЛ



5+


насандaa үржилд орно.



Бие гүйцсэн атуу


18.000

түрс гаргана.



4.0-6.0°C

АМЬДРАЛЫН ЭРГЭЛТ



ЗАГАСНЫ ТҮРСНИЙ ӨСӨЛТ, ХӨГЖИЛ


Усны температур нь хөврөлийн хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд үр тогтсон өндгөн эсээс авгалдай гарах, жарамгай, жараахайн шат хүртэл хэр хугацаа шаардахыг тодорхойлдог.



Монгол хадран загасны эр
бэлгийн эс /сун/

1-2 секундэд

үр тогтооно.



10-14 хоног

нүд нөсөөжинэ.




22-28 хоног

биеийн контур үүсч эхэлнэ.



31-35 хоног

авгалдай гарч эхэлнэ.



38-42 хоног

жарамгайн шатанд шилжинэ.




49-55 хоног

жараахайн шатанд шилжинэ.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Монгол хадран загасны шилжилт хөдөлгөөний судалгааг орон нутгийн байгаль орчны байгууллагуудын төлөөлөл ШУА-н Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны нөөц, ус ашиглалтын салбараас төлөөлсөн эрдэмтэн судлаачдын хамтарсан баг 2017-2019 онуудад улиралын чанартай хийсэн. Нийт 362 ширхэг загасанд уян тэмдэглэгээ зүүж буцаан байгальд нь тавьсан байна. Судалгааны үр дүнд Шижигтийн хавцалд Хар ус нуураас уян тэмдэглэгээ зүүсэн загас дахин баригдсан нь Шижигтийн хавцалаас Ховд гол уруудан 100 гаруй км шилжилт хийснийг илэрхийлж байна. Түүнчлэн Ховд гол өгсөөд Баяннуур орчмын Өндөр модноос Карасын тохой хооронд уян тэмдэглэгээ зүүсэн загас дахин баригдсан байна. Ийнхүү Монгол хадран загас Хар ус нуураас Ховд голын эх хүртэл чөлөөтэй шилжилт хөдөлгөөн хийдэг болох нь шинжлэх ухааны судалгаагаар батлагдсан байна (Мэндсайхан ба бусад, 2020; <http://portal.igg.ac.mn>).



Уян тэмдэглэгээ
зүүсэн хадран загас

ХАМГААЛЛЫН СТАТУС

Монгол хадран нь Олон улсын Загасны улаан дансанд "эмзэг" ангилалд багтсан бөгөөд манай орны улаан номонд орсон, унаган зүйл загас юм.



ХОВОРДЛЫН ШАЛТГААН



Усны
түвшний
хэлбэлзэл



Амьдрах
орчны
доройтол



Хууль бус
агнуур



Хэт
олборлолт



УЦС-ын
боомт, далан
хаалт

Усан цахилгаан станцын боомт бусад төрлийн далан хаалт нь загасны үржил, шилжилт хөдөлгөөн таслах, тусгаарлах гол хүчин зүйл болдог нь олон улсад судалгаагаар нотлогдсон. Иймд Монгол хадран загасыг зориудын аргаар үржүүлж жараахайг боомтын дээд, доод урсгалд тавих нь загасны популяцийн нэгдмэл орчин бий болгоход байгаль хамгааллын ихээхэн ач тустай.



Тэмдэглэл

[illegible]

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас манай орны унаган зүйл Монгол хадран загасны биологи-экологи, нас, өсөлт, идэш тэжээлийн онцлог, үржил, амьдралын эргэлт, шилжилт хөдөлгөөн, хамгааллын статус болон хамгааллын ажилд зориулагдав.

Энэхүү ажилд ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Монгол-Оросын хамтарсан Биологийн иж бүрэн экспедицийн эрдэмтэн, судлаачдын хэвлэн нийтлүүлсэн ажлын үр дүнгээс оруулсан.

Боловсруулж/хянан тохиолдуулсан:

Доктор Б. Мэндсайхан, ШУА-ын Газарзүй-Геоэкологийн хүрээлэн
С.Пүрэвдорж, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол
дахь хөтөлбөрийн газар

Зургийг зурсан: Б. Энхзол

Эх бэлтгэсэн: Х.Балдандорж, Ч.Баярмаа

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН
(WWF)-ГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО НЬ
ЭХ ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ДОРОЙТЛЫГ ЗОГСООЖ, ХҮН ТӨРӨЛХТӨН
БАЙГАЛЬТАЙГАА ШҮТЭЛЦЭН АМЬДРАХ
ИРЭЭДҮЙГ БҮТЭЭХЭД ОРШИНО.

Холбоо барих хаяг:

Утас: +(976)-11-311658

Факс: +(976)-11-310237

И-мэйл: info@wwf.mn



mongolia.panda.org